



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Цогт сумын Баянтоорой тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГАА-2022/20/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор:	Х.Түвшинбаяр
	Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn	
	Аудитын менежер:	Д.Эрдэнэчимэг
	Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn	
	Ахлах аудитор:	Ж.Бүжинханд
	Утас: 99177546 Цахим хаяг: Vujinkhandj@audit.gov.mn	
	Аудитор:	Н.Гэрэлмаа
	Утас: 99782918 Цахим хаяг: gerleen1111@gmail.com	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/ ...	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/	8
3. Аудитын тайлан	9
3.1. Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга	10
3.5.1 Орлогын данс	11
3.5.2 Зардлын данс	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлсэн сан



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЦОГТ СУМЫН
БАЯНТООРОЙ ТОСГОНЫ ЗАХИРАГЧ
Д.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.25 № 190
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

07020497

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	196,377.8	300,558.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	33,822.7	33,885.5
33	АВПАГА	25,735.1	93,504.3
35	БАРАА МАТЕРИАЛ	132,315.3	168,664.4
36	НӨӨЦИЙН БАРАА	4,504.6	4,504.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,181,357.3	2,226,478.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,181,357.3	2,226,478.6
39200	Биет хөрөнгө	2,116,914.2	2,162,672.8
39300	Биет бус хөрөнгө	64,443.2	63,805.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,377,735.1	2,527,037.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	797.5	18,699.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	797.5	18,699.6
41300	Өглөг	797.5	18,699.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,376,937.6	2,508,337.8
51	Засгийн газрын хувь оролцоо	2,376,937.6	2,508,337.8
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	431,666.7	431,666.7
51200	Хуримтлагдсан үр дүн	812,381.0	943,781.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,132,889.9	1,132,889.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,377,735.1	2,527,037.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,688,997.0	1,655,142.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	16,145.7	18,593.1
110	Орлогын албан татвар	12,436.7	15,469.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	12,436.7	15,469.1
113	Хөрөнгийн албан татвар	420.0	140.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	3,289.0	2,984.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	101,595.9	229,638.7
120	Нийтлэг татварын бус орлого	101,595.9	229,638.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,571,255.5	1,406,910.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,733,030.6	1,523,742.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,733,030.6	1,523,742.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,399,348.4	1,452,559.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	901,684.0	918,322.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,117.3	123,084.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,528.3	79,493.4
2104	Хангамж, бараа материалын зардал	72,359.8	54,180.4
2105	Нормативт зардал	59,909.2	126,218.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,691.0	8,502.0
2107	Томилолт, зочны зардал	2,290.0	2,807.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,044.8	33,130.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	118,724.0	106,821.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	333,682.2	71,182.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-44,033.6	131,400.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-44,033.6	131,400.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,626,625.2	1,366,787.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	16,145.7	18,593.1
110	Орлогын албан татвар	12,436.7	15,469.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	12,436.7	15,469.1
113	Хөрөнгийн албан татвар	420.0	140.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	3,289.0	2,984.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,726.0	2,584.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	200.0	400.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,404.1	9,917.0
120	Нийтлэг татварын бус орлого	27,404.1	9,917.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,583,075.5	1,338,277.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,612,524.3	1,364,225.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,612,524.3	1,364,225.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,265,898.1	1,293,037.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	901,900.5	918,322.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,956.9	123,250.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,360.7	74,241.8
2104	Хангамж, бараа материалын зардал	58,529.5	48,034.1
2105	Нормативт зардал	50,041.6	75,228.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,197.8	7,157.0
2107	Томилолт, зочны зардал	2,290.0	2,807.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,803.2	33,130.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,818.1	10,865.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	346,626.2	71,188.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	14,101.0	2,562.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,980.0	2,500.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,980.0	2,500.0
2200	Дотоод эх үүсвэрээр	2,980.0	2,500.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,980.0	-2,500.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	11,121.0	62.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,701.7	33,822.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	33,822.7	33,885.5

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,420,971.2	2,420,971.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,420,971.2	2,420,971.2
9	Тайлант үеийн үр дүн	-44,033.6	-44,033.6
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,376,937.6	2,376,937.6
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,376,937.6	2,376,937.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,376,937.6	2,376,937.6
19	Тайлант үеийн үр дүн	131,400.1	131,400.1
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,508,337.8	2,508,337.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,352,107.00	1,308,473.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,352,107.00	1,308,473.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,322,839.00	1,279,516.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	930,844.90	913,541.02
210101	Үндсэн цалин	709,501.90	700,920.61
210102	Нэмэгдэл	66,798.00	66,798.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,600.00	3,600.00
210104	Урамшуулал	63,987.00	56,019.59
210105	Гэрээт ажлын хөлс	86,958.00	86,202.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	130,446.30	122,682.02
210201	Тэтгэврийн даатгал	92,281.90	88,421.71
210202	Тэтгэмжийн даатгал	9,466.60	7,211.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,801.80	7,384.56
210204	Ажилгүйдлийн даатгал	1,903.70	1,797.17
210205	Эрүүл мэндийн даатгал	18,992.30	17,867.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,024.90	74,241.75
210301	Гэрэл, цахилгаан	7,527.20	6,753.53
210302	Түлш, халаалт	67,497.70	67,488.22
2104	Хангамж, бараа материалын зардал	47,218.60	43,593.77
210401	Бичиг хэрэг	3,797.20	3,589.83
210402	Тээвэр, шатахуун	34,913.90	32,233.24
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,718.20	1,527.60
210404	Ном, хэвлэл	200.00	99.90
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,276.00	1,274.10
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,313.30	4,869.10
2105	Нормативт зардал	82,527.60	73,848.23
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,669.30	20,161.72
210502	Хоол, хүнс	52,758.30	51,249.87
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,100.00	2,436.65
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,660.00	9,657.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500.00	2,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	960.00	960.00
210604	Урсгал засвар	6,200.00	6,197.00
2107	Томилолт, зочны зардал	2,991.00	2,256.00
210702	Дотоод албан томилолт	2,991.00	2,256.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,257.50	29,830.86
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,121.60	27,702.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,098.00	1,098.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125.00	125.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350.00	350.00
210807	Газрын төлбөр	60.00	60.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	102.90	102.86
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	400.00	393.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,868.20	9,865.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,090.10	8,089.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,778.10	1,775.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,268.00	28,957.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,268.00	28,957.19
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,668.00	18,357.19
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,600.00	10,600.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,352,107.00	1,308,482.13

31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,087,828.50	1,070,003.23
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,087,828.50	1,070,003.23
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	252,761.90	236,809.50
320001	Орон нутгийн төсвөөс	252,761.90	236,809.50
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11,516.60	343.35
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,516.60	343.35
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	1,326.05
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	720.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	606.05
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	8.78

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,426.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	40,426.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,020.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,781.00
210104	Урамшуулал	4,781.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	568.59
210201	Тэтгэврийн даатгал	454.39
210202	Тэтгэмжийн даатгал	35.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	28.65
210204	Ажилгүйдлийн даатгал	4.52
210205	Эрүүл мэндийн даатгал	45.22
2104	Хангамж, бараа материалын зардал	4,440.31
210401	Бичиг хэрэг	1,180.00
210402	Тээвэр, шатахуун	2,644.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	615.42
2105	Нормативт зардал	1,380.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,380.00
2107	Томилолт, зочны зардал	551.06
210702	Дотоод албан томилолт	551.06
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,405.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,600.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,805.59
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг	2,805.59
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	41,844.04
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,844.04
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,573.74
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,517.80
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	8,752.50
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	1,417.50
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,417.50

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цогт сумын Баянтоорой тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд байгууллагуудын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, төсвийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Гэрэлмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Цогт сумын Баянтоорой тосгоны захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цогт сумын Баянтоорой тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Засаг даргын хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нь цаг үеэ олсон оновчтой зөвлөгөө, мэдээллээр ханган бүх талын дэмжлэг үзүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй чанарын өндөр түвшинд хүргэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Цогт сумын Баянтоорой тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цогт сумын Баянтоорой тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 1,499.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 30.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 24.0 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 1,523.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 30.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 24.4 сая төгрөгөөр тогтоогдсон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Цогт сумын Баянтоорой тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6.3 хувиар буюу 149.3 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 33.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 33.9 сая төгрөг болж 0.06 сая төгрөгөөр өссөн нь ЭМТ-ийн дансанд мөнгө үлдсэнтэй холбоотой байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 25.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 93.5 сая төгрөг болж өссөн нь тайлант хугацаанд цэцэрлэгт НДШ-тэй холбоотой авлага үүссэн, ЭМТ-д төлбөртэй ажил үйлчилгээний авлага үүссэнтэй тус тус холбоотой.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 132.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 168.7 сая төгрөг болж 36.4 сая төгрөгөөр өссөн нь бараа материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 246.0 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 80.4

сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 287.5 сая төгрөгийн материалыг зарцуулж, 1.9 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 2,181.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 2,226.5 сая төгрөг болж 45.1 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2.5 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 160.0 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой байна.

Өр төлбөрийн дансны эхний үлдэгдэл 0.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 18.7 сая төгрөг болж 17.9 сая төгрөгөөр өссөн нь сургуульд НДШ-тэй холбоотой 0.3 сая төгрөгийн, эрүүл мэндийн төвд 18.4 сая төгрөгийн өр үүссэнтэй тус тус холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,508.3 сая төгрөг болж 131.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 2.1 хувиар буюу 33.9 сая төгрөгөөр буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 0.9 сая төгрөг болсон байна.

3.5.1 Орлогын данс

Тайлант онд 18.6 сая төгрөгийн татварын орлого, 229.6 сая төгрөгийн татварын бус орлого, 1,406.9 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого нийт 1,655.1 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

3.5.2 Зардлын данс

Тайлант онд 1,523.7 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

3.5.3 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Цогт сумын ИТХ-ын 2021 оны 7 дугаар сарын “Сумын 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 01 дүгээр тогтоолд зааснаар Цогт сумын Баянтоорой тосгоны сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 8.4 сая төгрөгийн татварын, 3.1 сая төгрөгийн татварын бус нийт 11.5 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 27.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 236 хувиар биелүүлсэн байна.

Орон нутгийн орлогыг төлөвлөснөөс бууны албан татвар 0.04 сая төгрөгөөр тасарсан байна. Аудитаар татварын бааз суурийг хамруулж үзээгүй тул орлого тасарсан үндэслэлийг тодорхойлох боломжгүй байлаа.

Орлогын гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад өндөр дүнгээр нэмэгдсэн татварын болон татварын бус орлогын төрөл байхгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Цогт сумын Баянтоорой тосгоны төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төслийг нэгтгэн гараагүй байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 1,352.1 сая төгрөгийг сумын төсвөөс 2021 оны төсвийн жилд зарцуулахаар баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 1,352.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,352.1 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,087.8 сая төгрөгийг улсын төсвөөс буюу тусгай зориулалтын шилжүүлгээс, 252.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 11.5 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн санхүүжилтийг тус тус бүрэн авсан. ЭМТ нь ЭМДСангаас 11.2 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,308.5 сая төгрөг буюу 96,8 хувьтай байгаа нь зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд

- Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөнөөс 30.6 сая төгрөг
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 2.5 сая төгрөг
- Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого 8.7 сая төгрөг нийт 41.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 4.8 сая төгрөг, нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 0.6 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 4.4 сая төгрөг, нормативт зардалд 1.4 сая төгрөг, томилолтын зардалд 0.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 3.3 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1.0 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 21.6 сая төгрөг нийт 40.4 сая төгрөгийг зарцуулж мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1.4 сая төгрөг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

ТТЗ : Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 36 мэдээллээс 34 мэдээллийг “Цогт сум Баянтоорой” цэсэнд ил тод бүрэн байршуулсан байна. Нийцсэн

бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Цогт сумын Баянтоорой тосгоны Соёлын төв тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 8 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд :

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 16.0 сая төгрөгийн 1 заалт албан шаардлага хүргүүлсэн бөгөөд шийдвэрийн хэрэгжилтийг хангасан байна.

Харьяа нэгж байгууллагын тухайд:

Сургуулийн хувьд өмнөх шийдвэрийн үлдэгдэл 5.3 сая төгрөгийн үлдэгдэл байгаа нь цалингийн нөхөн олговрын авлага байна.

Цаашид санхүүгийн ажилтны хариуцлагыг сайжруулан зөрчлийг давтан гаргахгүй байж өмнөх аудитын шийдвэрийг хангаж ажиллах нь зүйтэй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар орон нутгийн орлого, татварын тодорхойлолт, өмнөх шийдвэрийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

Дараа жилийн түүвэрт хамрагдах нэгж байгууллагын аудитаар цалин, бараа материалын тайлангийн зарцуулалт, төсвийн хэмнэлтийн горимыг хэрхэн хэрэгжүүлж ажилласныг шалгах нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 4 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллага, 1 байгууллагын ажил гүйлгээг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 2, “Хязгаарлалттай” 2 дүгнэлт өгсөн байна.

Дүгнэлт гарсан нэгж байгууллагын аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг аудитын дүгнэлт гарсан нэгж байгууллагуудад 50.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 27.4 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 22.8 сая төгрөгийн 14 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 5.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 44.7 сая төгрөгийн алдааг залруулж, 0.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 59.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3 алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийгдсэн залруулга:

Цогт сумын Баянтоорой тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар залруулга гараагүй.

Түүвэрт хамрагдсан байгууллагын тайланд хийгдсэн залруулга:

Соёлын төв нь тайлант онд 0.5 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг нөхөж шивүүлсэн.

4.2 Төвлөрүүлэн захирагчийн Төлбөрийн акт

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хувьд

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

Түүвэрт хамрагдсан байгууллага

Ээлжийн амралт, цалинг давхардуулан олгосон 0.1 сая төгрөг байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, ер төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Төвлөрүүлэн захирагчийн Албан шаардлага

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хувьд

Бууны албан татварыг 0.04 сая төгрөгөөр тасарсан нь Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр тогтоол, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Түүвэрт хамрагдсан байгууллага

Цогт сумын Баянтоорой тосгоны Соёлын төв:

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүй, төсөвт 10%-с доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй байгаа нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.1-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах," гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 0.02 сая төгрөгийн илүү, 0.2 сая төгрөгийн дутуу нийт 0.2 сая төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг

зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Төвлөрүүлэн захирагчийн Зөвлөмж

Түүвэрт хамрагдсан байгууллага

Аудитаар Захирагчийн ажлын алба, Сургууль, Цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан боловч дүгнээгүй зөрчлийг арилгах 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн ажлын алба:

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан боловч дүгнээгүй байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д "Өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 16 дугар зүйлийн 16.5.7-д "Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

Цогт сумын Баянтоорой тосгоны Сургууль:

- 1.3. Илрүүлэлт: Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан боловч дүгнээгүй байна.
- 1.4. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д "Өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 16 дугар зүйлийн 16.5.7-д "Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

Цогт сумын Баянтоорой тосгоны Цэцэрлэг:

- 1.5. Илрүүлэлт: Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан боловч дүгнээгүй байна.
- 1.6. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д "Өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 16 дугар зүйлийн 16.5.7-д "Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

Цогт сумын Баянтоорой тосгоны Соёлын төв:

- 1.7. Илрүүлэлт: Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан боловч дүгнээгүй байна.

- 1.8. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д “Өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”, 16 дугар зүйлийн 16.5.7-д “Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

Цогт сумын Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төв:

- 1.9. Илрүүлэлт: Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан боловч дүгнээгүй байна.
- 1.10. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д “Өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”, 16 дугар зүйлийн 16.5.7-д “Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/сая төгрөгөөр/							
				Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
ТТЗ											
	Цогт сумын Баянтоорой тосгоны сумын ТТЗ	1	0.04	0	0	0	0	1	0.04	4	0
Түүвэрт хамрагдсан байгууллага											
	Соёлын төв	3	0.3	0	0	1	0.1	2	0.2	0	0
	Дүн	3	0.3	0	0	1	0.1	2	0.2	4	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	ТТЗ	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Соёлын төв	1	0.6	1	0.6	0	0	0	0	1	0
	Дүн	1	0.6	1	0.6	0	0	0	0	1	0
	Нийт дүн	10	0.9	1	0.6	1	0.1	3	0.2	5	0